

180



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Журам, зөвлөлийн бүрэлдэхүүн
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам"-ыг хоёрдугаар, "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ыг гуравдугаар, "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргах өргөдлийн маягт"-ыг дөрөвдүгээр, "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг бүртгэх дэвтрийн загвар"-ыг тавдугаар, "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг бүрдүүлэлтийн тайлангийн маягт, багц цаг бүрдүүлсэн хэлбэрийг бүртгэх код"-ыг зургаадугаар, "Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар"-ыг долоодугаар, "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн гэрчилгээний загвар"-ыг наймдугаар, "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулгын маягт"-ыг есдүгээр, "Зөвшөөрлийн шалгалтын комиссын гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэгийн маягт"-ыг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 199 дүгээр тушаал, 2011 оны 280 дугаар тушаал, 2012 оны 404 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
05 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- Зөвлөлийн дэд дарга: ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын
Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрлийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн;
- Гишүүд:
 - ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
 - ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
 - ЭМЯ-ны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
 - ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар, Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн дарга;
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсролын газрын дарга (зөвшилцсөнөөр);
 - Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр);
 - Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн ажиллах хүчний шилжилтийн албаны дарга (Гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэхэд оролцох);
 - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга (Гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэхэд оролцох);
 - Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн дарга (тухайн мэргэжлийн чиглэлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэхэд оролцох);
 - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга;

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ,
НӨХӨН ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (цаашид "Зөвшөөрөл" гэх)-тэй холбоотой үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хууль, энэхүү журам, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.
- 1.2. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) ажиллах ба Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын алба нь зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг (цаашид "ажлын алба" гэх) хэрэгжүүлнэ.
- 1.3. Энэхүү журам нь хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллаж байгаа болон анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж төгсөж, дээрхи чиглэлээр ажиллах гэж буй эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна.
- 1.4. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт (цаашид "зөвшөөрлийн шалгалт" гэх)-ын дүн, багц цагийн биелэлтийг үндэслэн 2 ба 5 жилийн хугацаагаар олгоно. Зөвшөөрөл олгосныг нотлох баримт нь зөвшөөрлийн гэрчилгээ байна.
- 1.5. Эмнэлгийн мэргэжилтний төрөлжсөн мэргэжлээрээ ажиллах баталгаа нь тухайн мэргэжлийн сургалтанд суралцсаныг нотлох диплом буюу түүнтэй адилтгах баримт бичиг байна.
- 1.6. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн нь эхний жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт, хоёр дах жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд их эмчээр ажиллана.

Хоёр. Нэр томьёо

Энэхүү журамд бичигдсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллахыг баталгаажуулсан баримтыг;

2.2. “Төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт” гэж анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их, дээд сургууль, коллеж төгссөнөөс хойш мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх бүхий л хугацаанд эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхээр хийж буй сургалтыг;

2.3. “Багц цаг” гэж эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургалтын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг;

2.4. “Багц цагийн баталгаажуулалт” гэж эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд суралцаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлснийг нотлох, баримтжуулах үйл явцыг ойлгоно.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа

3.1 Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.1.1 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;
- 3.1.2 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд бодлогын зөвлөгөө өгөх;
- 3.1.3 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмжийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлах;
- 3.1.4 Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавих;
- 3.1.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг Монгол Улсад ажиллуулах мэргэжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулах;
- 3.1.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох, эсэх талаар хэлэлцэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал хүргүүлэх;
- 3.1.7 Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв зэрэг байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг хүчингүй

184
болгох саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх ба гишүүдийн саналыг цахим болон цаасан хэлбэрээр авч дүгнэлт гаргаж болно.

3.3 Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Зөвлөлийн дарга батлах ба шаардлагатай үед даргын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг нэмэлтээр хэлэлцэж болно.

3.4 Зөвлөлийн дарга хурлын дэгийг батална.

3.5 Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулгын хамт, зөвлөлийн даргад танилцуулж батлуулан, Зөвлөлийн гишүүдэд хурал болохоос ажлын 3 хоногийн өмнө хүргүүлсэн байна.

3.6 Зөвлөл нь сард 1 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн даргын санаачлагаар ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

3.7 Зөвлөлийн гишүүдийн 2/3 нь ирсэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр байна

3.8 Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай бүрэн танилцаж саналаа бэлтгэж ирэх ба оролцох боломжгүй үед саналаа бичгээр ирүүлнэ. Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн ажиллах хүчний шилжилтийн албаны дарга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга нар гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэхэд оролцоно.

3.9 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцсэн асуудлын тэмдэглэл хөтөлж, даргаар хянуулж, дарга болон гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

3.10 Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь ажлын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Дөрөв. Зөвлөлийн ажлын албаны чиг үүрэг

4.1 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.2 Зөвшөөрлийн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулах;

4.3 Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах;

4.4 Дотоодын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох асуудлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж, Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зөвшөөрлийн зөвлөлөөр хянуулан, шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан, баталгаажуулах;

185

4.5 Багц цагийн бүрдэлт, зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

4.6 Зөвшөөрлийн мэдээний санг дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн тус бүрээр бүрдүүлэн ажиллуулж, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн талаархи мэдээллийг www.chd.moh.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлэх;

4.7 Зөвшөөрөл олгосон, нөхөн олгосон, хүчингүй болгосон тохиолдолд цахим мэдээний санд тухай бүр тусгах;

4.8 Зөвшөөрлийн шалгалтын сорилын санг бүрдүүлэн, сангийн 50-иас доошгүй хувийг жил бүр шинэчлэн, баяжилтыг тогтмол хийж, нууцлалыг ханган ажиллах;

4.9 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийж, судалгааны үр дүнг Зөвлөлөөр хэлэлцүүлэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, судалгааны мэдээллийн сан үүсгэх;

4.10 Шаардлагатай тохиолдолд гадаад орны холбогдох байгууллагатай харилцаж, зөвшөөрөл хүссэн гадаадын эмнэлгийн мэргэжилтний талаар тодорхойлолт, тодруулга авах;

4.11 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл олгоход шаардагдах баримт бичгийн бүрдэлтийг хянаж, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;

4.12 Зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаанд явцын хяналт тавих;

4.13 Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, хуулийн байгууллага зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл харилцан солилцох;

Тав. Зөвшөөрлийн шалгалт

5.1 “Зөвшөөрлийн шалгалт” гэж эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох зорилгоор тухайн мэргэжлээр ажиллахад шаардлагатай мэдлэгийн түвшинг баталгаажуулах үйл явцыг хэлнэ.

5.2 Зөвшөөрлийн шалгалтанд тэгш, хараат бус, ил тод байх, шударга өрсөлдөх зарчмыг баримтална.

5.3 Зөвшөөрлийн шалгалтыг олон хувилбарт сорилоор авна.

5.4 Зөвшөөрлийн шалгалтыг нийслэлд цахим хэлбэрээр 7 хоног бүр, цаасан хэлбэрээр сар тутамд, орон нутагт хагас жилд нэг удаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн даргын тушаалаар томилсон шалгалтын комисс /цаашид “комисс “гэх / авна.

5.5 Комиссын гишүүн комисст ажиллахыг зөвшөөрсөн тухайгаа энэхүү тушаалын аравдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, гарын үсгээ зурж

баталгаажуулан шалгалт эхлэхээс 2-оос доошгүй хоногийн өмнө Эрүүл мэндийн хөгжлийн төвийн даргад өгсөн байна.



5.6 Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл нь энэхүү журмын хүрээнд холбогдох чиглэлээр зөвшөөрлийн шалгалтын сорилыг боловсруулж, сорилын санд байршуулах ба сорил, сорилын түлхүүрийг нэгдсэн сангаас тухай бүр бэлтгэнэ.

5.7 Зөвшөөрлийн шалгалтын сорил нь дотоодын ба гадаадын эмнэлгийн мэргэжилтний гэсэн 2 төрөлтэй байна.

5.8 Зөвшөөрлийн шалгалтын сорилын 50 хувь нь ерөнхий мэргэжлийн, 30 хувь нь төрөлжсөн мэргэжлийн анагаах ухааны, 10 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 5 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуултууд байна.

5.9 Дараах нөхцөлд эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтанд орох хүсэлт гаргана:

5.9.1 Хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж төгсөгчид;

5.9.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан хугацаагаар ажилласан хүний их эмч;

5.9.3 Зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд багц цагийн биелэлтийг хангаагүй эмнэлгийн мэргэжилтэн;

5.9.4 Энэхүү журмын 6.7.1, 6.7.2-д заасны дагуу зөвшөөрлийг хүчингүй болгосон хугацаа нь дуусч, зөвшөөрөл олгох эрх үүссэн, 6.7.3, 6.7.4-д заасан эмнэлгийн мэргэжилтэн.

5.10 Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий дотоодын их, дээд сургууль, коллеж нь жил бүрийн төгсөлтийн шалгалт дууссанаас хойш 30 хоногийн дотор төгсөгчдийн нэрсийг баталгаажуулсан жагсаалтыг Ажлын албанд албан тоотоор ирүүлнэ.

5.11 Зөвшөөрлийн шалгалтанд орох хүсэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хаяг (<http://www.chd.moh.mn>) - аар эсвэл цаасан хэлбэрээр гаргана.

5.12 Зөвшөөрлийн шалгалтыг цахим эсвэл цаасан хэлбэрээр авна.

5.13 Зөвшөөрлийн шалгалтанд 70 буюу түүнээс дээш оноо авсан мэргэжилтэнд зөвшөөрөл авах эрх үүснэ.


5.14 Ажлын алба нь нийслэлд зохион байгуулсан шалгалтын дүнг шалгалт авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт, орон нутагт зохион байгуулсан шалгалтын дүнг шалгалт авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан тус тус нэгтгэж, тухайн хугацаанд багтаан (<http://www.chd.moh.mn>) цахим хуудсанд байршуулна.

5.15 Зөвшөөрлийн шалгалтанд тэнцэж зөвшөөрөл авах эрх үүссэн эмнэлгийн мэргэжилтэн дараах материалуудыг Ажлын албанд бүрдүүлж өгнө. Үүнд:

5.15.1 Зөвшөөрөл хүссэн өргөдөл (Энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу);

5.15.2 Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар;

- 5.15.3 4x6 хэмжээтэй зураг 2 хувь;
5.15.4 Шалгалт болон гэрчилгээний хураамж төлсөн баримт;
5.15.5 Өмнөх зөвшөөрлийн хуулбар (зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаад дахин авч буй тохиолдолд).



5.16 Зөвшөөрлийн шалгалттай холбоотой гомдлыг шалгалтын комисст гаргаж болно. Комисс гомдлыг судалж, хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.

5.17 Гомдол гаргагч шалгалтын комиссын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд Ажлын албанд хүсэлтээ тавьж шийдвэрлүүлж болно.

Зургаа. Зөвшөөрөл олгох, нөхөн олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох

6.1 Зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох эмнэлгийн мэргэжилтний нэрс бүхий шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, баталгаажуулна.

6.2 Зөвшөөрлийн гэрчилгээг зөвшөөрлийн шалгалт авсан өдрөөс хойш 20 хоногт багтаан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баталгаажуулан олгоно.

6.3 Энэхүү журмын 6.1-т заасан шийдвэрийн төслийн үнэн зөв байдлыг Ажлын алба бүрэн хариуцна.

6.4 Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох тушаалд эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг ташаа бичсэнээс зөвшөөрлийн гэрчилгээ алдаатай болсон тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга магадлах комисс томилон, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр залруулга хийх бөгөөд алдаа гаргасан албан тушаалтнаар гэрчилгээний тэмдэгтийн хураамжийг төлүүлнэ.

6.5 Зөвшөөрлийн гэрчилгээг гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгох ба тухайн эмнэлгийн мэргэжилтэн дараах материалыг бүрдүүлэн Ажлын албанд хүсэлтээ гаргана:


- 6.5.1 Зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн, гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл;
- 6.5.2 Зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт;
- 6.5.3 Зөвшөөрлийн гэрчилгээг хэвлүүлэх бодит зардлын төлбөрийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дансанд шилжүүлсэн төлбөрийн баримт.

6.6 Ажлын алба нь энэхүү журмын 5.15-д заасан материалыг хянаж, зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох үндэслэлтэй (зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй, өмнөх оны багц цаг биелсэн) гэж үзвэл зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох ба энэ тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтанд орох шаардлагагүй.

6.7 Зөвшөөрлийг дараах тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хүчингүй болгон, нийтэд мэдээлнэ:

- 6.7.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу;
- 6.7.2 Шүүхийн шийдвэрийн дагуу;
- 6.7.3 Багц цаг биелүүлээгүй бөгөөд зөвшөөрлийн шалгалтанд ороогүй буюу тэнцээгүй;
- 6.7.4 Нэг жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй.

Долоо. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цагийн биелэлт, бүртгэл



- 7.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын агуулгын багтаамжийг багц цагаар тодорхойлно. Уг сургалтын 1 багц цаг нь лекцийн 12, дадлагын 24 цагтай тус тус дүйцнэ.
- 7.2 Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, хүний бага эмч, эх баригч, сувилагч, эм найруулагч жил тутам 3 багц цагийн багтаамж бүхий сургалтанд хамрагдана.
- 7.3 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусч буй, эрүүл мэндийн байгууллагад эзэмшсэн мэргэжлээрээ тасралтгүй 25 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон мэргэжлээрээ ажиллаж буй Монгол Улсын Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтнууд жил тутамд 1,5 багц цагаас доошгүй сургалтанд хамрагдана.
- 7.4 Энэхүү тушаалын тавдугаар хавсралтаар загвар нь батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цагийн биелэлт бүртгэх дэвтэр” (цаашид “багц цагийн дэвтэр” гэх)-ийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй эмнэлгийн мэргэжилтэн бүрт байна.
- 7.5 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цагийн биелэлтийг өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч; сум, тосгоны эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн эрхлэгч; Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-15.1.10 -д заасан байгууллага болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан хянан үзэж, багц цагийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулан, энэхүү тушаалын зургаадугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу байгууллагын тамга дарж, багц цаг биелүүлсэн болон биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар (цаашид “аймаг, нийслэлийн ЭМГ” гэх)-т жил бүрийн 11 сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлнэ.
- 7.6 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн энэхүү журмын 7.5-т заасан жагсаалтыг нэгтгэн, Ажлын албанд жил бүрийн 12 сарын 10-ны дотор албан тоотоор ирүүлнэ. Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12 -д заасан байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн багц цаг биелүүлсэн болон биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг Ажлын албанд жил бүрийн 11 сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлнэ.
- 7.7 Ажлын алба нь ирүүлсэн тайланг хянаж, энэхүү журмын 7.2, 7.3 -т заасан багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг тухайн оны эцэст хүчингүйд тооцон, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.
- 7.8 Энэхүү журмын 7.7-д заасан зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй болгохтой холбоотой асуудлыг Ажлын алба бүрэн хариуцна.
- 7.9 Энэхүү журмын 7.7-д заасан эмнэлгийн мэргэжилтний нэрсийг www.chd.moh.mn цахим хуудсанд байршуулан, зөвшөөрлийн шалгалтанд орохыг

шаардсан мэдэгдлийг харьяалах аймаг, нийслэлийн ЭМГ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд жил бүрийн 12 сарын 25-ны дотор хүргүүлнэ.

7.10 Багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтэн дараа оны эхний хагас жилд багтаан зөвшөөрлийн шалгалт өгнө. Зөвшөөрлийн шалгалтанд тэнцээгүй буюу эхний хагас жилд багтан шалгалтанд ороогүй эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалт дахин өгч тэнцэх хүртэлх хугацаанд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

7.11 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл нь зөвшөөрлийн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэйд тооцогдоно.

7.12 Багц цагаа тасралтгүй биелүүлж ажилласан, 5 жилийн хугацаатайгаар зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтэн нь зөвшөөрлийн хугацаа дуусахад, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Эрүүл мэндийн тухай хуульд заасан хугацаагаар зөвшөөрлийг шууд олгоно.

7.13 Багц цагийн бүрдүүлэлт, оноо тооцох аргачлал:

№	Багц цагийг бүрдүүлэх хэлбэр	Тооцох багц цаг	Баталгаажуулах баримт
А. Албан сургалт			
1.	Резиденсийн сургалтанд суралцсан жил тутамд	6	Дүнгийн дэвтэр, төгссөн мэргэжлийн үнэмлэхний хуулбар
2.	Мэргэжил олгох сургалт	дээд мэргэжилтэн	Үнэмлэхний хуулбар
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	
3.	Мэргэжил дээшлүүлэх сургалт	дээд мэргэжилтэн	Үнэмлэхний хуулбар
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	
4.	Магистрын сургалтанд суралцсан жил тутамд	6	Дүнгийн дэвтэр, төгссөн мэргэжлийн үнэмлэхний хуулбар
5.	Докторын сургалтанд суралцсан жил тутамд	6	
Б. Албан бус сургалт			
1.	Семинарт оролцох	1	Албан шийдвэр, хөтөлбөр, урилга
	1.1 Олон улсын хэмжээнд	0,5	
	1.2 Улсын хэмжээнд	0,25	
2.	Мэргэжлийн төрөлжсөн зөвлөлгөөн, хуралд илтгэл тавих	1	Илтгэлийн хураангуй
	2.1 Олон улсын хэмжээнд	0,5	
	2.2 Улсын хэмжээнд	0,25	
	2.3 Орон нутгийн хэмжээнд		
3.	Эмгэг судлалын конференцид оролцох	0,1	Ирцийн бүртгэл
4.	Зайны сургалтанд суралцах	Зөвшөөрөгдс	Хөтөлбөр, сэдэв,

		өн багц цаг	сертификат
5.	Ажлын байран дээрхи болон сэдэвчилсэн сургалт	Зөвшөөрөгдсөн өн багц цаг	Батлагдсан сургалтын сэдэв, гэрчилгээний хуулбар
6.	Мэргэжлийн зэрэг хамгаалах	дээд мэргэжилтэн	6
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	3
В. Судалгаа шинжилгээний ажил, бүтээл, практикт нэвтрүүлсэн шинэ санаачлага			
1.	Илтгэл тавих		
	1.1 Байгууллагын хэмжээнд	1	Хурлын илтгэлийн хураангуйн нэр бүхий хуудасны хуулбар
	1.2 Их дээд сургуулийн хэмжээнд	2	
1.3 Улс, олон улсын хэмжээнд	3		
2.	Оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулахад оролцох	Стандарт тутамд 3	Батлагдсан стандартын хуулбар
3.	Судалгааны ажил удирдах	6	Судалгааны ажлын тайлан
4.	Судалгааны багт орж ажиллах	3	Судалгааны ажлын тайлан
5.	Төсөл, хөтөлбөр боловсруулах, ажлын хэсэгт орж ажиллах	1 х.х ¹ тутамд 0,5	Батлагдсан төсөл, хөтөлбөрийн баримт бичиг
6.	Мэргэжлийн зөвлөмж хэвлүүлэх	Зөвлөмж тутамд - 1	Хэвлүүлсэн сэтгүүлийн хувь
7.	Гарын авлага, аргачлал боловсруулж, хэвлүүлэх	Нэг бүр - 2	Хэвлүүлсэн сэтгүүлийн хувь
8.	Мэргэжлийн ном туурвих	1 х.х тутам - 1 8 х.х дээш - 6	Зохиогчийн нэр бүхий номын нүүрний хуулбар
9.	Мэргэжлийн ном туурвихад оролцох, шүүмж, дүгнэлт гаргах, хянах	1 х.х тутам - 0,5 8 х.х дээш - 3	Зохиогчийн нэр бүхий номын нүүрний хуулбар
10.	Мэргэжлийн ном орчуулах	1 х.х тутам - 0,25 8 х.х дээш - 3	Орчуулсан хүний нэр бүхий номын нүүрний хуулбар
11.	Мэргэжлийн ном орчуулахад хамтрах	1 х.х тутам - 0,1 8 х.х дээш - 1,5	Орчуулсан хүний нэр бүхий номын нүүрний хуулбар
12.	Шинэ бүтээл, тэргүүн туршлага гаргаж, баталгаажсан байх	6	Тухайн хүний нэр бүхий зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар
13.	Мэргэжлийн сургалтанд хичээл заах	6ц лекц тутамд-1, 12 ц дадлага тутамд -1	Сургалтын батлагдсан хөтөлбөр

¹ х.х – хэвлэлийн хуудас

14.	Олон нийтийн мэдээлэлийн хэрэгслээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийсэн тохиолдолд	Телевизийн нэвтрүүлгийн 30' тутамд 0,1	Сургалт явуулсан тухай бичлэгийн хуулбар
		Сонины 1/8 нүүр тутамд 0,1	Сонины хуулбар
15.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн	Шинээр нэвтрүүлсэн шинэ арга технологи 0,5	Тухайн байгууллагын удирдлагын зөвлөлийн тодорхойлолт, хагас бүтэн жилийн тайланд тусгагдсан байх, мэдээний сангийн бүртгэлд давхцаагүй байх



7.14 Багц цагийн бүрдүүлэлт, оноо тооцох аргачлалын 14, 15-д заасан хэлбэрээр тухайн жилийн багц цагийн 25 хүртэлх хувийг бүрдүүлэхийг зөвшөөрнө.

7.15 Эмнэлгийн мэргэжилтний тухайн жилд биелүүлсэн багц цаг нь энэхүү журмын 7.2, 7.3 - т зааснаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.

7.16 Эмнэлгийн мэргэжилтэн нь гадаадад төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд суралцсан тохиолдолд багц цагийг дотоодын сургалттай адилтган үзэж гэрчилгээ, үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн тооцно.

7.17 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт эрхлэх зөвшөөрөлтэй байгууллагын зохион байгуулсан сургалтаар олгогдсон багц цагийг хүчинтэйд тооцно.

7.18 Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд хамруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ.


7.19 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтыг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулна.

Найм. Мэдээний сан

8.1 Ажлын алба нь эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн мэдээний санг дотоодын эмнэлгийн мэргэжилтэн, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл хүчингүй болсон мэргэжилтэн гэсэн 3 төрлөөр бүрдүүлэн ажиллана. Түүнчлэн эмнэлгийн мэргэжилтний багц цагийн бүрдүүлэлтийн мэдээний санд эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, технологийг тогтмол бүртгэнэ.

8.2 Ажлын алба нь зөвшөөрлийн мэдээний сангийн баяжилтыг сар бүрийн 5-ны дотор хийсэн байна.

8.3 Ажлын алба нь зөвшөөрлийн мэдээний санд үндэслэн улирал тутамд болон жилийн эцэст тайлан гарган Зөвлөл болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд албан тоотоор хүргүүлж, <http://www.chd.moh.mn> цахим хуудсанд байршуулна.



Ес. Хяналт, хариуцлага

9.1 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь ажлын албаны үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тогтмол хийж, үр дүнг тооцон шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9.2 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар улирал бүр, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хагас жил тутамд тус тус хяналт үнэлгээ хийнэ.

9.2 Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний дүнг Зөвлөлийн хурлаар тухай бүр хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын чиглэл, хариуцлагын арга хэмжээний саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

9.3 Энэхүү журмыг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэн, Эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эмчлэх, сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (цаашид “Зөвшөөрөл” гэх) олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна.
- 1.3. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) тодорхойлсон Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн дагуу зөвхөн төрөлжсөн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ.
- 1.4. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд “эм барих”, “эх барих” чиглэлээр зөвшөөрөл олгохгүй бөгөөд гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэлтэй ирж, үйл ажиллагаа явуулах тохиолдолд эм, эмнэлгийн хэрэгслийн зөвшөөрлийн асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Импортын лиценз олгох журам”-ын дагуу зохицуулна.
- 1.5. “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 1.2 дах заалт, 3, 4, 8, 9 дүгээр бүлгийн заалтууд энэхүү журамд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хоёр. Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

- 2.1 Дараах шалгуурыг хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргана:
 - 2.1.1 Анагаах ухаан, сувилахуйн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 2.1.2 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичигтэй байх;
 - 2.1.3 Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр суралцсныг нотлох хүчин төгөлдөр баримт бичигтэй байх;
 - 2.1.4 Тухайн мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх.
- 2.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж буй Монголын талын байгууллага нь (цаашид “байгууллага” гэх) гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг Монгол Улсад ирэхээс ажлын 20-иос доошгүй хоногийн өмнө дараах материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын алба (цаашид “Ажлын алба” гэх)-д ирүүлнэ. Үүнд:

- 2.2.1 Тухайн мэргэжлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах хэрэгцээг тодорхойлсон албан бичиг;
- 2.2.2 Байгууллагын даргын баталсан “Гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө”;
- 2.2.3 Мэргэжилтний танилцуулга (эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлагдсан маягтын дагуу);
- 2.2.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний паспорт, түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.6 Анагаах ухааны чиглэлээр боловсрол эзэмшсэнийг нотлох үнэмлэх, диплом түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.7 Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр суралцсныг нотлох хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.8 Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн ажиллах хүчний шилжилтийн албаны лавлагаа;
- 2.2.9 Энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасныг нотлох орчуулагчийн баримт

2.3 Ажлын алба нь энэхүү журмын 2.2-т заасан материалыг хүлээн авч хянан, шаардлага хангасан байгууллагын хүсэлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

2.4 Зөвлөл тухайн мэргэжлийн чиглэлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг ажиллуулах хэрэгцээг харгалзан, зөвшөөрөл олгохыг дэмжих эсэх талаар санал гаргана.

2.5 Зөвлөлөөс гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг Монгол Улсад 6 сар ба түүнээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжсэн тохиолдолд тухайн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25.5-д заасны дагуу монгол хэл дээр орчуулагчгүйгээр зөвшөөрлийн шалгалт өгөх ба шалгалтыг ажлын алба зохион байгуулна. Зөвшөөрлийн шалгалтанд тэнцээгүй тохиолдолд дахин шалгалт авахгүй.

2.6 Зөвшөөрлийн шалгалтын сорилын 20 хувь нь ерөнхий мэргэжлийн, 70 хувь тухайн төрөлжсөн мэргэжлийн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн талаарх асуултууд байна.

2.7 Зөвшөөрлийн шалгалтыг Зөвлөлийн шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан цаасан хэлбэрээр авч, шалгалтын дүнг шалгалт авсан өдрөөс хойш ажлын 2 өдөрт багтаан <http://www.chd.mn/> цахим хуудсанд байршуулна.

2.8 Зөвшөөрлийн шалгалтын үйл ажиллагаанд энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 5.1-5.3, 5.5, 5.6, 5.13, 5.16, 5.17 дах заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.9 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад үргэлжлүүлэн ажиллах тохиолдолд ажиллуулж буй байгууллага зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 20-оос доошгүй хоногийн өмнө журмын 2.2-т заасан материалыг дахин бүрдүүлж, хийсэн ажлын тайлангийн хамт ажлын албанд ирүүлнэ.

2.10 Ажлын алба нь дор дурьдсан гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалт бүхий шийдвэрийн төслийг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газраар хянуулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баталгаажуулна. Үүнд:

- 2.10.1 Зөвлөлөөс 6 сараас доош хугацаагаар ажиллахыг дэмжсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн;
- 2.10.2 Зөвлөлөөс 6 сараас дээш хугацаагаар ажиллахыг дэмжсэний дагуу шалгалтанд орж тэнцсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн;

2.11 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөл олгох тухай шийдвэрийн төслийг баталгаажуулахад дараах материалыг хавсаргасан байна. Үүнд:

- 2.11.1 Зөвлөлийн санал, дүгнэлт,
- 2.11.2 Шалгалтын комиссын дүгнэлт

2.12 Энэхүү журмын 2.2-т заасан материалыг дутуу эсвэл хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд зөвшөөрлийг олгохгүй.

2.13 Монгол Улсад тохиолдсон байгалийн гамшиг, осол, нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлт болон бусад онцгой тохиолдлын үед Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр ирж ажиллах гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр ажлын 1 өдөрт багтаан олгож болно.

2.14 Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг ард, иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор тус улсад богино хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн, зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шууд олгож болно.

2.15 Засгийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвтэй байгуулсан урт хугацаагаар хамтран ажиллах гэрээний дагуу өмнөх жил ирж ажиллахдаа ямар нэг зөрчил гаргаагүй гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дахин ирж буй тохиолдолд асуудлыг Зөвлөлөөр хэлэлцүүлэхгүйгээр Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газраар хянуулан, ажлын 10 хоногийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баталгаажуулснаар зөвшөөрлийг олгож болно.

2.16 Энэхүү журмын 2.10, 2.13, 2.14, 2.15-д заасан шийдвэрийн төслийн үндэслэл, үнэн зөв байдлыг ажлын алба бүрэн хариуцна.

Гурав. Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж буй байгууллагын эрх, хүлээх үүрэг

3.1 Байгууллага нь дараах эрхтэй:

- 3.1.1 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн асуудлаар санал, хүсэлт гаргаж, журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэх;
- 3.1.2 Хэрэв урьсан байгууллага гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд цалин олгох бол цалин, хөлсийг хууль, журамд нийцүүлэн тогтоон, олгох;
- 3.1.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг гэрээний дагуу ажиллахыг шаардах;

3.1.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн гэрээний заалт биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах.

3.2 Байгууллага нь дараах үүрэгтэй:

3.2.1 Энэхүү журмын 2.2-т заасан баримт бичгүүдийг журамд заасан хугацаанд үнэн, зөв бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.2.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллах;

3.2.3 Зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж үйлчилгээг монгол хэлээр үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх, энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасан орчуулагч ажиллуулах;

3.2.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй хийсэн гэрээгээ цуцалсан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор ажлын албанд албан тоотоор мэдэгдэх;

3.2.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг ажиллуулсан тухай тайлан, тухайн мэргэжилтэнтэй хийсэн гэрээний хуулбарыг түүний зөвшөөрлийн хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ажлын албанд ирүүлэх;

3.2.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд хуулийн хариуцлага бүрэн хүлээх.

3.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй байгуулах гэрээнд байгууллага нь дараах нөхцөлийг заавал тусгана:

3.3.1 Ажиллах хугацаа;

3.3.2 Албан тушаал, ажлын газрын хаяг, ажиллах нөхцөл;

3.3.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл;

3.3.4 Цалин хөлсний хэмжээ, олгох хугацаа болон нийгмийн даатгалын шимтгэл, татварын асуудлыг холбогдох хууль журмын дагуу тооцох;

3.3.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд үүрэх хариуцлага.

3.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй ажиллах орчуулагч нь дараах шаардлагыг хангасан байна.

3.3.6 Тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтний эх хэлний дээд түвшний мэдлэгтэй, түүнийг гэрчилсэн үнэмлэх, баримт бичигтэй байх,

3.3.7 Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр орчуулга хийж байсан туршлагатай буюу түүнийг гэрчилсэн баримт бичигтэй байх (өмнө нь орчуулга хийж байсан эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт г.м)

Дөрөв. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

4.1 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах эрхтэй:

4.1.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулах байр, орчинг бүрдүүлэхийг шаардах;


4.1.2 Энэхүү журмын 3.4-т заасан шалгуур хангасан орчуулагчтай ажиллах.

4.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:

4.2.1 Монгол Улсад ажиллах хугацаандаа Монгол Улсын хууль, тогтоомжийг бүрэн сахиж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах;

4.2.2 Зөвхөн тухайн мэргэжлээр авсан зөвшөөрлийн хүрээнд, зөвлөлөөс тогтоосон хугацаанд үйл ажиллагаа явуулах;

- 4.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авах;
- 4.2.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай үзүүлэх.



Тав. Зөвшөөрлийг хүчингүй болгох, мэдээлэх

5.1 Дараах тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 5.1.1 Байгууллагын болон гадаадын эмнэлгийн мэргэжилтний санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцалсан;
- 5.1.2 Байгууллага болон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, бусад хуулийг зөрчсөн нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 5.1.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон.

5.2 Ажлын алба нь гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрийн төслийг боловсруулж Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газраар хянуулан, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж баталгаажуулна.

5.3 Энэхүү журмын 5.2-т заасан шийдвэрийн төсөл, зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй болгохтой холбоотой асуудлын үнэн зөв байдлыг ажлын алба бүрэн хариуцна.

5.4 Ажлын алба нь зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийг хүчингүй болгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтний талаархи мэдээллийг зөвшөөрлийн мэдээний санд бүртгэн, цахим хуудас (<http://www.chd.moh.mn>)-д байршуулж Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд албан тоотой хүргүүлнэ.

Зэрэг	Авсан огноо	Үнэмлэхний дугаар



15. Боловсролын зэрэг

Хаана	Огноо	Сэдэв	Боловсролын болон эрдмийн цол, зэрэг	Үнэмлэхний дугаар

16. Мэргэшлийн бэлтгэл

(Ажил, мэргэжил, бусад чиглэлээр суралцаж, мэргэшсэн байдлыг бичнэ)

Хаана	Эхэлсэн он, сар	Дууссан он сар	Мэргэшлийн чиглэл	Гэрчилгээ/ сертификатын дугаар

17. Ажилласан туршлага

Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он

Зөвшөөрөл олгох хүсэлт

18. Зөвшөөрлийн төрөл (зурах)

/эмчлэх, сувилах, эх барих, эм барих/

19. Хүсэлт гаргасан удаа (зурах)

/анх удаа, давтан/

20. Хэрэв давтан авч байгаа бол хүчингүй болсон шалтгаан (зурах)

- Эрүүл мэндийн тухай хуулийн 26.3 - д заасны дагуу;
- Эрүүгийн хуулийн 101.1, 102.1, 104.2, 105.1, 106.1-д заасны дагуу;
- Багц цаг биелүүлээгүй бөгөөд дараа оны эхний хагас жилд багтаан шалгалтанд ороогүй буюу тэнцээгүй;
- Нэг жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй;
- Гэмтээсэн, үрэгдүүлсэн.


Хүсэлт гаргасан огноо

он

сар

өдөр

oo O oo



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ МЭРГЭШҮҮЛЭХ
БОЛОН ДАВТАН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГИЙН ДЭВТЭР (ЗАГВАР)

Ерөнхий мэдээлэл:

1. Эцэг (эхийн) нэр _____

2. Өөрийн нэр _____

3. Хүйс

4. Төрсөн он сар өдөр

5. Гэрийн хаяг:
Аймаг, хот

Сум Дүүрэг

6. Иргэний үнэмлэхийн сери дугаар

7. Регистрийн дугаар

8. Шуудангийн хаяг _____

9. И-мэйл хаяг _____

10. Утасны дугаар: Ажил

Гэр

Гар

11. Байгууллага: Улсын Хувийн

12. Ажлын хаяг: _____

Аймаг, хот

Сум Дүүрэг

13. Албан тушаал: _____

14. Төгссөн сургууль (анагаахын ухааны боловсрол олгох сургууль, төгсөлтийн дараах сургалтыг бичнэ)

Сургууль	Орсон он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом/гэрчилгээний дугаар



15. Ажилласан туршлага

Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он

16. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн талаарх мэдээлэл:

Гэрчилгээ:

Зөвшөөрлийн төрөл	Гэрчилгээний дугаар	Олгосон огноо	Дуусах огноо	тайлбар

17. Багц цагийн бүртгэл:

№	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр						Нийт багц цаг	Огноо	Хянасан
	Албан сургалт	цаг	Албан бус сургалт	цаг	Судалгааны ажил, бүтээл	цаг			



**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ МЭРГЭШҮҮЛЭХ БОЛОН
ДАВТАН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ**

МАЯГТ 2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтний жагсаалт

Байгууллагын нэр:.....

№	Овог, нэр	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн дугаар	Олгосон огноо	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр				Нийт багц цаг		
					Албан сургалт	Албан бус сургалт	Судалгааны ажил, бүтээл	Нийт			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

БАТАЛГААЖУУЛСАН
(Байгууллагын дарга)
.....
(гарын үсэг)

00000

22

МАЯГ 3. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжлийн жагсаалт



Байгууллагын нэр:

№	Овог, нэр	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн дугаар	Олгосон огноо	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр				Нийт багц цаг	Дутуу багц цаг		
					Албан сургалт	Албан бус сургалт	Судалгааны ажил, бүтээл	Бусад				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13

БАТАЛГААЖУУЛСАН
(Байгууллагын дарга)
.....
(гарын үсэг)

00000

3. БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛСЭН ХЭЛБЭРИЙГ БҮРТГЭХ КОД

Доорх кодыг ашиглан Багц цагийн баталгаажуулалтын хүснэгтийн 6, 8, 10, 12 дахь баганад тохирох кодыг, 7, 9, 11, 13 дахь баганад харгалзах багц цагийг оруулан бүртгэнэ.



А. Албан сургалт (багана 6)

- А 1. Резиденсийн сургалт
- А 2. Мэргэжил олгох сургалт
- А3. Мэргэжил дээшлүүлэх сургалт
- А 3. Магистрын сургалт
- А 4. Докторын сургалт

АБ. Албан бус сургалт (багана 8)

АБ 1. Семинарт оролцох

- АБ 1.1 Олон улсын хэмжээнд
- АБ 1.2 Улсын хэмжээнд
- АБ 1.3 Орон нутгийн хэмжээнд

АБ 2. Мэргэжлийн төрөлжсөн зөвлөгөөн, хуралд илтгэл тавих

- Б 2.1 Олон улсын хэмжээнд
- Б 2.2 Улсын хэмжээнд
- Б 2.3 Орон нутгийн хэмжээнд

АБ 3. Эмгэг судлалын конференцид оролцох

АБ 4. Зайны сургалтанд хамрагдах

АБ 5. Ажлын байран дээрхи болон сэдэвчилсэн сургалтанд хамрагдах

АБ 6. Мэргэжлийн зэрэг хамгаалах

С. Судалгааны ажил, бүтээл (багана 10)

С 1. Илтгэл тавих

- С 1.1 Байгууллагын хэмжээнд
- С 1.2 Их, дээд сургуулийн хэмжээнд
- С 1.3 Улс, олон улсын хэмжээнд

С 2. Оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулахад оролцох

С 3. Судалгааны ажил удирдах

С 4. Судалгааны ажлын багт оролцох

С 5. Төсөл, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажиллах

С 6. Мэргэжлийн зөвлөмж хэвлүүлэх

С 7. Гарын авлага, аргачлал боловсруулах

С 8. Мэргэжлийн ном туурвих

С 9. Мэргэжлийн ном туурвихад оролцох, шүүмж, дүгнэлт гаргах, хянах

С 10. Мэргэжлийн ном орчуулах

С 11. Мэргэжлийн ном орчуулахад хамтрах


С 12. Шинэ бүтээл, тэргүүн туршлага гаргах

С 13. Мэргэжлийн сургалтанд хичээл заах

С14. Олон нийтийн мэдээлэлийн хэрэгслээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийх

С15. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээнд шинэ арга, технологи нэвтрүүлэх

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07-ны өдрийн 68 дугаар
тушаалын долоодугаар хавсралт



**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР**

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан хугацаагаар хүний их эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар шаргал дэвсгэртэй, тод шаргал угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэндийн яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Хүний их эмч овогтой-д

Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын
.....-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатай олгов.

САЙД.....


..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

ooOoo

2. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-д заасан хугацаагаар хүний их эмчид олгох "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар ногоон ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.



Хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амын их эмч
(аль нэгийг бичих)

..... овогтой-д


Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын
.....-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан бага эмчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

3. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-д заасан хугацаагаар хүний бага эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:



- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэндийн яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Хүний бага эмч овогтой-д


Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн тоот тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан хүний бага эмчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

ooOoo



4. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.5-д заасан хугацаагаар эх баригчид олгох "Эх барих" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эх барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар бор шаргал дэвсгэртэй, гадуураа тод бор шаргал өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эх баригч овогтой-д
 Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
 тоот тушаалаар ЭХ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх
 зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын
-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эх баригчийн 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

5. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.4-д заасан хугацаагаар сувилагчид олгох “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:



- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар цэнхэр дэвсгэртэй, хөх өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэндийн яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Сувилагч овогтой-д


Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын
.....-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан сувилагчийн 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

6. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.3-д заасан хугацаагаар эм зүйчид олгох “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна.



- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэндийн яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эм зүйч овогтой-д

Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар ЭМ БАРИХ эрхийн зөвшөөрлийг оны
.....сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5
жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эм зүйчийн 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.



7. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.3-д заасан хугацаагаар эм найруулагч олгох "Эм барих" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", түүний доод хэсэгт "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эм найруулагч овогтой-д


Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар ЭМ БАРИХ эрхийн зөвшөөрлийг оны
.....сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5
жилийн хугацаатай олгов.

САЙД

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эм найруулагчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын наймдугаар хавсралт



1. Гадаадын хүний их эмчид Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4-д заасан хугацаагаар олгох зөвшөөрөл нь дараах бичлэгтэй байна:

1. Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй, цайвар ягаан дэвсгэртэй, ягаан өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
2. Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэндийн яам", түүний доод хэсэгт "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн гэрчилгээ" гэж бичсэн байна.
3. Гэрчилгээ нь нууцлалтай байна.
4. Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

..... улсын харьяат

.....-д Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн тоот тушаалаар мэргэжлээр **ЭМЧЛЭХ** үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна

ooOoo

2. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4-д заасан хугацаагаар олгох зөвшөөрөл нь дараах бичлэгтэй байна:

- Зөвшөөрлийн гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй, цайвар ягаан дэвсгэртэй, ягаан өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэндийн яам”, түүний доод хэсэгт “Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн гэрчилгээ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.



..... улсын харьяат
.....-д
Эрүүл мэндийн сайдын оны сарын өдрийн
..... тоот тушаалаар мэргэжлээр
СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын
ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл
..... хугацаатай олгов.

САЙД
..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний зураг байрлуулна.
- Гэрчилгээг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж албажуулна

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын есдүгээр хавсралт

ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ТАНИЛЦУУЛГЫН МАЯГТ



Байгууллагын мэдээлэл:

1. Урьж буй байгууллагын нэр
2. Урьж буй байгууллагын хаяг
3. Холбоо барих утас, хариуцах хүн /урьж буй байгууллагын/ Эмнэлгийн мэргэжилтний нэр

Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээлэл:

4. Овог нэр
5. Нас
6. Хүйс
7. Яс үндэс
8. Үндсэн захиргаа
9. Паспортын дугаар, хүчинтэй байх хугацаа
10. Монгол улсад зорчихоор мэдүүлсэн визийн ангилал төрөл
11. Боловсрол
12. Мэргэжлийн чиглэл, зэрэг
13. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, олгогдсон огноо, хүчинтэй байх хугацаа
14. Урьд эрхэлж байсан ажил (он дарааллаар):
15. Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:
16. Монгол улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан зөвшөөрлийн төрөл
17. Үзүүлэх гэж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэл (дэлгэрэнгүй бичнэ, тухайлбал хийгдэх мэс заслын нэрийг), үндэслэл

3x4 зураг

Урьж буй байгууллагын дарга /нэр/

Гарын үсэг, тамга, тэмдэг

ooOoo

215

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 07 ны өдрийн 68 дугаар
тушаалын аравдугаар хавсралт



**ШАЛГАЛТЫН КОМИССЫН ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАХЫГ
ЗӨВШӨӨРСӨН МЭДҮҮЛЭГ**

/ Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд томилогдсон гишүүдэд хамаарна/

..... албан тушаалтай овогтой
..... би

/ Шалгалтын комиссын гишүүн нэр, албан тушаалаа бичнэ/

ЭМХТ-ийн даргын оны тоот тушаалаар шалгалтын комиссын
гишүүнээр томилогдон ажиллахыг зөвшөөрч, энэхүү мэдэгдлээр дараах баталгааг
гаргаж байна:

Нэг.

1.1 Би тухайн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтнүүдтэй сонирхлын
зөрчилгүй, хэрэв сонирхлын зөрчил бий болох нөхцөл үүссэн тохиолдолд
шударгаар мэдэгдэж комиссын гишүүнээс татгалзана.

1.2 Шалгалт авах үйл ажиллагаанд хувийн сонирхлоор бус, хөндлөнгийн
байр сууринаас хандана.

1.3 Миний хараат бус, хөндлөнгийн байр сууринаас хандах байдалд нөлөө
үзүүлэхүйц нөхцөл байдал байхгүй болно.

Хоёр. Шалгалтын бэлтгэл ажил болон шалгалт авах үйл ажиллагааг Авлигын эсрэг
хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг
сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтний
ёс зүй хэм хэмжээг баримтлан, заагдсан эрх үүргийн дагуу шударга гүйцэтгэнэ.

Гарын үсэг.....

Огноо.....

Албан ажлын хэрэгцээнд:

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо	Цаг, минут
Хүлээн авсан					